

ФИЛОСОФИ СЭТГЭЛГЭЭНИЙ ТҮҮХЭНД “МЕНТАЛИТЕТ” ХЭМЭЭХ ОЙЛГОЛТЫН ФИЛОСОФИ УТГЫН ХУВЬСАЛ

Г.Лодой /зөвлөх профессор, доктор (Ph.D)/
МУИС, Философи, шашин судлалын тэнхим
В.И. Павлов /доктор (Ph.D)/
МУИС, Европ судлалын тэнхим

Түлхүүр үг: Улс төрийн тогтолцоо, үнэлэмж, глобальчлал, газар зүй, өвөрмөц шинж, ертөнц, хүрээлэн буй орчин, оюун санаа, төсөөлөл, харилцан үйлчлэл, чиг баримжаалал, ертөнцийг хуран мэдэхүй, ертөнцийг ойлгохуй.

Товч агуулга: Хүн төрөлхтөн үндэстэн хоорондын, үндэстэн доторх тэмцлийг зогсоохын тулд харилцааны тэнцвэр, түүний уялдаа холбоог өнөө хүртэл хайсаар л байгаа. Иймд аливаа улсын дотоод хэрэгт гаднаас зэвсэг хэрэглэж оролцох нь тухайн улсын ард түмний угсаатан хоорондын харилцааг тогтворжуулдаггүй, харин эсрэгээр олон жилийн турш далд байсан зөрчлийг ил гаргаж улмаар угсаатан хоорондын харилцааны тэнцвэр алдагдаж, улс хямралд ордог. Энэхүү хямралын шалтгаан нь төрийн явуулж буй улс төр ба эдийн засгийн бодлого нь тухайн ард түмний менталитет, ертөнцийг үзэхүй, уламжлал, үнэлэмжийн тогтолцоотой зөрчилд орсонтой холбоотой юм. Үүний улмаас явуулж буй төрийн бодлого үр дүнд хүрдэггүй, цаашилбал, ард түмний дунд уг бодлогыг дэмжихгүй, тэдний эсэргүүцлийг бий болгодог юм. Өөрөөр хэлбэл, янз бүрийн салбарт хэрэгжүүлж буй төрийн бодлогыг маш нарийн, түүхийн олон үе шат дамжсан “менталитет”-ад тулгуурлан явуулахгүй бол үр дүн бага гардаг юм. Үүний улмаас л эртний сэтгэгч нар уг үзэгдлийг судлаж өөрийн үзэл бодлоо илэрхийлжээ.

XX зууны эхээр Орос улсад октябрийн хувьсгал ялснаар дэлхийн тавцанд нийгмийн хөгжлийн талаар эсрэг тэсрэг үзэл баримтлал бий болж, улмаар Дэлхийн хоёрдугаар дайны дараа социалист, капиталист хэмээн хоёр хүчирхэг улс төрийн тогтолцоо бий болсон. Энэ нь дэлхийн ард түмнийг хоёр хувааж, хүний оюун санааны томоохон үзэгдэл болох менталитет, ертөнцийг үзэхүйд бие биеэ үзэн ядах үзэл бодлыг бүрэлдүүлсэн юм. XX зууны эцэст дэлхийд болсон олон өөрчлөлтүүд энэ үзэн ядалтыг бууруулаагүй харин үндэстэн хоорондын харилцааны зөрчлийг улам гүнзгийрүүлж,

хурцадмал байдлыг нэмэгдүүлснээс гадна өөр өөр менталитеттэй ард түмэнг хооронд нь мөргөлдүүлж дэлхийн гуравдугаар дайн эхлэх шалтгаан ч болж хувирах магадлал бий болж байна гэж олон судлаач үздэг юм.

Ер нь хүн төрөлхтөн үндэстэн хоорондын болон үндэстэн доторх тэмцлийг зогсоохын тулд харилцааны тэнцвэр, түүний уялдаа холбоог өнөө хүртэл хайсаар л байна. Иймд аливаа улсын дотоод хэрэгт гаднаас зэвсэг хэрэглэж оролцох нь тухайн улсын ард түмний угсаатан хоорондын харилцааг тогтворжуулдаггүй гэдэг нь ойлгомжтой

асуудал. Бидний бодлоор уг тэнцвэр, төрийн явуулж буй эдийн засгийн өөрчлөн байгуулалт, аливаа үндэстний хөгжлийн үр дүн нь менталитет, ертөнцийг үзэхүй болон тэдний төлөвшүүлсэн үнэлэмжийн тогтолцоотой нягт холбоотой.

“Менталитет” хэмээх нэр томъёог XX зуунаас өмнө хүмүүнлэгийн шинжлэх ухаанд нийгмийн ухамсар, хүний сэтгэхүй ба үйл ажиллагааны онцлог, зан төлөв, иррационал сэдлүүд гэдэг ойлголттой холбодоггүй байлаа. Цаашилбал, хүн судлалд энэхүү нэр томъёо нь дээр дурдсан үзэгдлүүдийн нийлбэрийг илэрхийлэх зорилготойгоор бий болсон гэж үздэг тал ч байдаг. Тийм учраас “менталитет” хэмээх ойлголтыг утга ойролцоо “ухамсар”, “сэтгэхүй” гэдэг ойлголтуудаар хожим хэрэглэж эхэлсэн гэдэг.

Иймд уг нэр томъёог яагаад XX зуунд шинжлэх ухаанд, дараа нь ердийн хүрээнд хэрэглэж эхэлсэн бэ гэдэг асуулт зүй ёсоор гарч ирж байгаа юм.

Тэгвэл үүнийг дараах байдлаар тайлбарладаг. Юуны түрүүнд хүн төрөлхтөн дэлхийн хэмжээний геободлого, оюун санааны өөрчлөлтийн үе рүү орж байгаатай холбоотойгоос гадна “янз бүрийн бүс нутгийн ба эрин үеийн ухамсарууд”¹ хоорондоо “мөргөлдөж” нийгэм-соёлын ертөнцөд гарч буй олон тооны өөрчлөлттэй холбоотой. Нийгмийн ба хувийн ухамсрын өөрчлөлт нь өөрийгөө ухаарах, түүнийг өнөө үеийн нэр томъёогоор илэрхийлэх шаардлагыг бий болгодог ажээ. Орчин үеийн нийгэм

нь янз бүрийн соёлыг илэрхийлсэн олон үндэстнүүдээс бүрддэг. Иймд аливаа үндэстэнг төлөөлж буй хүмүүсийн өдөр тутмын хамтын ахуй, тэдний хоорондын харилцааг үр дүнтэй болгох хэрэгцээ нь үндэсний менталитетийн уг чанарыг дахин ухамсарлан ойлгох шаардлагыг бий болгодог.

Уг нь менталитет хэмээх нэр томъёог XIX зуунаас хэрэглэж эхэлсэн боловч, өнөөг хүртэл энэ ойлголт бага судлагдсан, их өргөн хүрээтэй үзэгдэл юм. Өөр нэг шалтгаан нь түүнд соёл, бие хүний чанаруудаас гадна, нийгмийн бүлгүүдийн зан төлөв байдлын онцлог, бүхэл бүтэн үеийн сэтгэлгээний хэв шинж ч багтдагтай холбоотой юм.

Үнэлэмж нь аливаа ард түмний өвөрмөц шинж, газар зүй, цаг уур, эдийн засаг, улс төрийн тогтолцоо г.м хүчин зүйлээс шалтгаалж бүрэлдэн тогтсон ертөнцийг үзэхүйгээс тодорхой хэмжээгээр хамаардаг нь ойлгомжтой. Энэ байдлыг Эпикур Геродотод явуулсан мэндчилгээндээ угсаатан бүр өөрийн өвөрмөц онцлогтой, оршин сууж буй газар нутгаас хамааран хоорондоо ялгаатай гэдгийг тэмдэглэсэн байдаг. Харин Геродот “Түүх” гэдэг бүтээлдээ эллин, перс ба бусад ард түмэн хоорондоо ертөнцийг ойлгохуйгаар ялгаатай байдаг гэдгийг мөн тэмдэглэжээ. “Германы нутаг дэвсгэрт оршин сууж буй омгууд нь өөр омгийн хүнтэй хэзээ ч цус холилддоггүй. Эрт дээр үеэс өөрийн цэвэр ариун байдлаа (ари) хадгалж, зөвхөн өөртэйгөө адилхан онцгой ард түмэн гэдгийг хүлээн зөвшөөрч буй бусадтай хүмүүстэй санал нэг байдаг”²

*Менталитет, менталь чанар (ментальность) хэмээх хоёр ойлголт нэг үзэгдлийг илэрхийлдэг гэж үзэж байгаа болно.

¹ Библер В.С. Итоги и замыслы: Конспект философской логики культуры // Вопросы философии. 1993. №5. с.75

² К. Тацит. Анналы. Малые произведения. История. М., 2004. с.986

хэмээн К.Тацит бичжээ. Дэлхийн хоёр дайныг эхлүүлсэн улс бол Герман.

Тацитын хэрэглэсэн “онцгой ард түмэн” хэмээх ойлголтыг Гитлер “онцгой үндэстэн” болгон тунхагласан бөгөөд тэр арьсны өнгөөр ялгаварлах үзэл баримтлалын хамгийн харгис шинж дээр тулгуурлан бусад ард түмэнг устгах, өөрийн эрхшээлд авах бодлого баримталж байжээ. Ер нь арьсны өнгөөр ялгаварлах үзэл бодлыг боловсруулж байсан эрдэмтдийн тоонд германы судлаачид нилээд их байдаг гэдгийг дурдах хэрэгтэй. Нөгөөтэйгүүр хүний арьсны өнгө амьдарч буй орчин, цаг уур, хоол хүнсээс хамаардаг нь ойлгомжтой юм. Үүнийг Ахмад Плиний “Байгалийн түүх” хэмээх бүтээлдээ тусгаж, янз бүрийн ард түмэн, тэдний зан төлөв байдал, сэтгэхүй нь оршин сууж буй газраас хамаардаг гэдгийг мөн тэмдэглэж байжээ.

Иймд дээрх хүчин зүйлүүд эрдэмтэн судлаач нарын анхаарлыг татдаг байсан ба тэд “менталитет” гэдэг ойлголтыг өөрийн үзэмжийн дагуу тайлбарладаг байлаа. Гэхдээ энэ үзэгдлийг тайлбарлахдаа “менталитетийн” детерминант болох газар зүй, цаг уур, хоол хүнсийг тэмдэглэж байсныг хожим нь олон тооны эрдэмтэн судлаачид өөрийн судалгаагаараа нотолсон гэж хэлж болно. XIX-XX зуунд нийгэм, соёл, хүн судлалын философи нь уг феноменыг зөвхөн рационал үүднээс судлаад зогсохгүй рациональ бус талаас нь ч судалж эхэлсэн бөгөөд үл ухамсарлахуй, архетип, пассионар г.м. бусад феномены гүний давхаргуудыг ч задлан шинжлэхийг оролддог байсан ба одоо ч энэ талаар судалгаа хийгдсээр л байна.

“Менталитет” хэмээх ойлголтыг саяхнаас (XX зууны эхэнд) хүмүүнлэгийн шинжлэх ухаанд хэрэглэж эхэлсэн гэж үздэг. Түүнчлэн энэ ойлголт нь зөвхөн өнгөрсөн үеийг бус өнөөгийн нийгмийн байдал, соёлыг тодорхойлохын зэрэгцээ нийгэмд байгаа хурц асуудлуудыг менталитетийн тусламжтайгаар шийдвэрлэх бололцоог ч нэмэгдүүлдэг. Энэ нь эерэг тал юм. Харин сөрөг тал нь энэ нэр томъёо өргөн хэрэглээтэй учраас олон утга санаа илэрхийлдэг. Тийм учраас агуулгыг нь тодорхойлоход хүндрэл тулгардаг ба өнөөдөр уг нэр томъёог бүрэн хэмжээгээр нь тайлбарласан нэгдсэн нэг тодорхойлолт байдаггүй нь үүнтэй холбоотой.

Уг нэр томъёоны үүсэл гарлыг хожим үеийн латин хэлний “mens”, “mentis” гэдэг язгуураас бий болсон гэдэг ба янз бүрийн хэлбэрээр санскрит хэлэнд хэрэглэдэг байжээ.ЭртнийЭнэтхэгийн“Упанишадууд (багшийн хөлд сөгдөхүй) хамгийн нэр хүндтэй, зонхилох нөлөө бүхий”³ бүтээлүүдэд “mens, mentis” гэдгийг “ухамсартай холбоотой”, “сэтгэхүйн”, “оюун санааны” гэдэг утгыг илэрхийлдэг гэж тайлбарласан байдаг. Цаашилбал уг ойлголт ухаан, сэтгэхүй, оюун бодол, сэтгэлгээний хэв маяг, ухамсар, ертөнцийг төсөөлөхүй, эрхэмлэл, ертөнцийг үзэхүй, үндэсний ухаарал г.м. утга илэрхийлж байсан бөгөөд өнөөдөр ч энэ санааг зарим эрдэмтэн судлаачид баримталдаг. Үүнээс улбаалан ойролцоо утга бүхий нилээд урт үгсийн хэлхээ бий болсон байна. Уг латин язгууртай төрөл нэг гэж үздэг герман хэлний “die mentalitat” сэтгэлгээний хэв

³ Ц.Гомбосүрэн., *Философи сурах бичиг.*, УБ.,2008. 36 тал

маяг, оюуны ухааны төлөв, англи хэлний “mentality” - оюун ухааны хөгжил, оюун ухааны төлөв, сэтгэхүйн төлөв байдал, франц хэлний “mentalite” сэтгэлгээний хэв маяг, сэтгэхүйн төлөв байдал, оюун ухааны баримжаалал, оюун ухааны төлөв г.м. ойлголтуудыг нэрлэдэг.

Эдгээр нь менталитет гэдэг нэр томъёог ойлгох асуудлыг хүндрүүлдэг нь ойлгомжтой. Нөгөөтэйгүүр эдгээрийг дүгнэн үзвэл, “менталитет”-ийг юуны түрүүнд ухамсар, сэтгэхүй, оюунлаг, өөрөөр хэлбэл хүний оюунлаг үйл ажиллагаа, түүний сэтгэхүйн үйл явц гэж ойлгож болох юм. Менталитетийн нэг гол чанар нь тогтвортой байдал, ө.х. амархан хувирдаггүй, өөрчлөгддөггүй чанар юм. Иймд менталитетийн энэ чанар нь ертөнцийг үзэхүй, үнэлэмжийн суурь болдог гэж хэлж болох юм.

Зарим эрдэмтдийн үзэж байгаагаар 1856 онд америкийн философч Р.Эмерсон нь менталитет гэдэг ойлголтыг шууд хэрэглээгүй ч утгыг нь илэрхийлсэн гэж үзэж болохоор ажээ. Тэрээр бүтээлдээ “Бид өнөө хүртэл аливаа өвөрмөц санааг зөвхөн бүх хүмүүсийн хүлээн зөвшөөрсөн, нэр хүнд бүхий сэтгэгчдэд хамаардаг гэж боддог. Гэвч бид өөрийн хамгийн далд санааг илэрхийлэхдээ хүмүүсийн төсөөтэй сэтгэлийн ачаар бусад хүмүүсийн хүртээл болгодог”⁴ гэж тэмдэглэжээ. Цаашилбал, “бид бүгд бидний ухамсарт оч мэт үе үе асч бадардаг гэгээлэг санааг отоож, мэдэрдэг байх ёстой ... энэ санаа нь хүн төрөлхтний санаатай зөрчилд хүргэсэн ч биднийг тайван, өөрийн сэтгэлийн эрмэлзэлд үнэнч

байлгадаг”⁵ гэж тэмдэглэжээ.

Дээр өгүүлснийг дүгнэн хэлбэл, Р.Эмерсон нь аливаа ард түмэнд өөрийн санаа байдаг, энэ санаа нь өрөөл бусдаас өөр байж болдог, энэ нь тухайн ард түмний өвөрмөц байдлыг хадгалахад тусалдаг гэж хэлсэн бололтой.

“Менталитет”-ийг танин мэдэхүйн хувьд төлөвших хугацаанд үндэсний зан төлөв байдал, ухамсар, сэтгэц, ард түмний санаа г.м. олон тооны ойлголтоор орлуулдаг байжээ. Гэхдээ янз бүрийн угсаатны ухамсар, сэтгэхүй хоёр өөр өөрийн өвөрмөц онцлогтой гэдгийг эртний философчид анзаарсан гэдгийг бид дээр дурдсан билээ.

Цаашилбал, эртний философчид мэдлэгийн эх үүсвэрийг байнга эрэлхийдэг байлаа. Тэр үеийн танин мэдэхүйн чадварын улмаас тэд анхдагч шалтгааныг янз бүрээр тодорхойлдог байв.

Тухайлбал Фалес анхдагч шалтгааныг чийг эсвэл ус гэж үздэг байсан бол Анаксимен – “түүний дотор, түүний организмын бүх үйлдлийг удирдаж буй хүч ба зарчим оршдог”⁶ гэдэг байв. Харин Эфессийн Гераклит нь “хүнд жинхэнэ мэдлэг байдаггүй харин Бурханд бий” гэж үздэг байжээ.

Анаксагор “нус” нь “оюун ухаан” гэдэг утгыг илэрхийлдэг учир түүнийг “менталитет” хэмээх ойлголттой адилтгаж болохгүй юм.

Гэвч өнөөдөр аливаа ард түмний сэтгэхүйн өвөрмөц онцлогийг тайлбарлахад бэрхшээлтэй тулгарахад

⁵ Там же. С. 4.

⁶ Льюис Дж.Г. Античная философия: от Фалеса до Сократа. Минск, 1997. С. 38

⁴ Р. Эмерсон. О доверии к себе. М., 1900 г. С. 3

“менталитет” гэдэг ойлголтыг хэрэглэгдэгтэй адил Анаксагор нь үл мэдэх шалтгааныг тайлбарлахдаа “нус”-анд (лат. оюун ухаан) ханддаг гэдгийг Аристотель анзаарчээ.

Аливаа оршин сууж буй нутаг, түүний цаг уур, цаг агаар, байгаль нь хүн амын амьдрахуйн хэв маягт, цаашилбал сэтгэхүйн хэв маягт ч нөлөөлдөг гэдгийг эртний Грекийн эмч Гиппократ “Агаар, ус, газрын тухай” хэмээх бүтээлдээ дурдаж байжээ.

Мөн Платон, Аристотель нар сэтгэхүйг, түүний танин мэдэхүйд хамаарах асуудлыг хөнджээ. Тухайлбал, Платон нь мэдлэгийг сэргээн санахуйн үр дүн, хүн мэддэг байсан зүйлээ л сэргээн санадаг учраас “танин мэдэх гэдэг нь урьд нь мэдэж байсан мэдлэгээ дахин сэргээхийг хэлнэ” гэж “Федон” хэмээх харилцан яриандаа тайлбарлажээ.

Сонирхол татаж буй өөр нэгэн баримт бол Платон нийгмийг олон давхаргад хувааж, давхраа бүр өөрийн менталь чанараараа хоорондоо ялгаатай байдаг гэжээ. Платон хүний сүнсийг оюун ухаалаг, сэтгэл хөдлөл, шуналын гэсэн гурван хэсэгт хуваажээ. Энэ гурван хэсгийн хоорондын харьцаанаас шалтгаалж хүмүүсийг янз бүрийн давхаргад багтаасан байна. Тухайлбал оюун ухааны хэсэг нь давамгайлж байвал уг хүн гүн ухаанч, хэрвээ сэтгэл хөдлөлийн хэсэг нь давамгайлж байвал цэрэг, шунал нь давамгайлж байвал тариачин буюу гар урлаач болдог гэжээ. Хүн төрөлхтнийг гурван давхаргаар хувааж, давхарга бүр нь байгалиас заяасан зүйлээ хийдэг гэжээ. Платоны энэ үзэл бодол нь хүн төрөлхтний

менталитет тогтвортой шинжтэй гэдгийг нотолж буй жишээний нэг гэж үзэж болох юм.

Харин Аристотелийнхаар хүн нийгмийн амьтан учраас зохион байгуулалттай байдаг. Энэ нь “хамт олны төсөөлөлтэй” байхыг шаарддаг гэсэн санааг дэвшүүлсэн гэж хэлж болох юм.

Хүний сэтгэлгээний энэхүү өвөрмөц хэв маягийг зөвхөн Эртний Грекийн философич, судлаачид хөндсөн гэж хэлж болохгүй. Менталитетийн асуудлыг эртний Энэтхэгийн философид ч хөндөж байжээ. Тухайлбал, Энэтхэгийн философид бие хүн физик, астраль болон сэтгэцийг илэрхийлдэг “менталь биеэс”⁷ бүрддэг гэж үздэг байв.

Нөгөөтэйгүүр, философид рациональ мэдлэгт үл итгэх байдал нэмэгдсэнээр шашны нөлөө өсчээ. Энэ байдал нь эртний философийн хожуу үеийн хэлбэр болох неоплатонизмаар илэрхийлэгдсэн гэдэг. Неоплатонизмыг үндэслэгч Ромын философч Плотин нь ахуйн үндсийг оюуны өмнөх тэнгэрлэг зарчим бүрэлдүүлдэг ба түүнээс ахуйн бусад хэлбэрүүд хамаардаг гэж үздэг байлаа. Тэрээр ертөнцийг рациональ ба далд хүчний гэж хоёр аргаар танин мэдэх боломжтой гэжээ. Гэхдээ далд хүчний аргыг буюу тэнгэрлэг аргыг гол арга, харин рациональ аргыг зөвхөн туслах үүрэг гүйцэтгэдэг гэж тайлбарлажээ.

Ер нь ухамсарын түвшинтэй холбоотой асуудал нь нарийн түвэгтэй асуудал гэдэгтэй маргахгүй байх. Сэтгэхүйн үйл ажиллагааны харьцангуй бага хэсгийг л субъект хяналтандаа байлгадаг, өөрөөр

⁷ Соционика, ментология и психология личности. 1997., с.115

хэлбэл ухамсарладаг, харин үлдсэн хэсэг нь үл ухамсарлахуй, далд ухамсарлахуйд үлддэг. Дээрх санааг З.Фрейд баримталдаг байсан ба хүний ухамсарт хүрээгүй үйл явцыг үл ухамсарлахуйн хүрээнд багтаажээ. Түүнийхээр хүний амьдрахуйн үйл ажиллагааны зохион байгуулалтанд нийгмийн ихэнх гишүүд хамрагддаг. Иймд тухайн нийгэм өөрийн гишүүддээ ухамсарлуулахыг үл хүссэн зүйлийг үл ухамсарлахуйн хүрээ рүү шахаж гаргадаг гэжээ. Энэ санааг Анаксагор дэвшүүлж байсан ба энэхүү хандлагыг З.Фрейд нарийвчлан судалж ухамсарын нэг түвшин нь үл ухамсарлахуй гэдэг санаа дэвшүүлсэн юм.

Дундад зуунд менталитетийг ойлгохуйг шашин, оюун санаа, теоцентризмын үүднээс үздэг байлаа. Үүнтэй холбоотойгоор энэ үеийн гол төлөөлөгч болох Гэгээн Августин нь нийгмийг баян, ядуу гэж хоёр давхаргаар хувааж, өмчийн ялгаа нь Бурханы үзэмж учраас мөнх үргэлжилнэ гэдэг байлаа. Гэгээн Августин нь сэтгэл, бие хоёрын харилцан хамаарлын тухай неоплатончуудын үзэл бодолтой санал нэг байсны улмаас сэтгэл бол хүний доторх бурханлаг талыг илэрхийлдэг, харин бие бол нүгэлийн эх сурвалж гэж үздэг байжээ.

Аквины Фома нь төрөлхийн мэдлэгийг үгүйсгэдэг байсан ч “зарим мэдлэгийн үр хөврөл” оршдог гэдэг санааг мөн дэвшүүлжээ. Энэ нь хожим Юнгийн дэвшүүлсэн “хамт олны үл ухамсарлахуй” хэмээх ойлголтыг бүрэлдүүлэхэд нөлөөлсөн байж болох юм. “Хамт олны үл ухамсарлахуйг” хүн төрөлхтний, өөрөөр хэлбэл, эртний хүн төрхтэй өвөг дээдсийн

ой санамжинд үлдсэн анхдагч мөр, архетипын агуулах гэж Юнг тодорхойлсон байдаг.

Иймд дундад зууны өрнө дахины философи нь оюун ухааны төлөв байдал, сэтгэхүйн хэв маягийн тухай дурддаг, ухамсарыг шашны ба шинжлэх ухааны гэж ялгадаг, хүнд урьдаас өгөгдмөл оюун санааны суурь үндэс байдаг гэж үздэг байв. Харин эдгээр нь менталитет, түүний үндсэн шинжүүдтэй хамааралтай гэдэг нь ойлгомжтой юм.

Шинэ үед шинжлэх ухааны мэдлэг нь илүү боловсронгуй болж, танин мэдэхүйн асуудал нь тэргүүлэх байр суурьтай болсон.

Ийм учраас л Ф.Бэкон, Ж.Локк, Лейбниц, Р.Декарт, Д.Юм ба бусад философчдийн анхаарлыг танин мэдэхүйн байр суурь, үнэний шалгуур, танин мэдэх арга, рациональ шинжүүдтэй холбоотой гэх мэтийн асуудлууд татах болжээ.

Эмпиризмыг үндэслэгч Английн философич, улс төрч Ф.Бэкон танин мэдэхүйг шинэ үзэл бодол, өөрөөр хэлбэл, туршлага ба оюун ухаантай холбон үздэг байжээ. Түүний үзэж байгаагаар жинхэнэ эрдэмтэн бол янз бүрийн цэцэгнээс “шүүс” цуглуулдаг ч түүнийгээ зөгийн бал болгож боловсруулдаг зөгийтэй адилхан байх ёстой гэжээ.

Ф.Бэконы дөрвөн төрлийн төөрөгдөл нь далд ухамсар ба хамт олны үл ухамсарлахуйд суугдсан ертөнцийг төсөөлөх онцгой төрлөөс бүрэлддэг учраас менталитеттэй шууд холбоотой. Ялангуяа омгийн төөрөгдөл нь хүн төрөлхтөнд хамаардаг хамгийн тогтвортой хий үзэгдэл.

Уг төөрөгдлийг өөрийн тогтвортой шинжээрээ, нийт хүн төрөлхтөнд хамаарагддагаараа К.Г.Юнгийн “хамт олны үл ухамсарлахуйтай” жишиж үзэж болох юм. Ер нь латин хэлний “idola” гэдэг үгийг шууд буулгавал “дүрслэл”, түүнчилэн нөлөөнд автагдсан дүрслэлийг мөн багтаадаг⁸. Харин К.Г.Юнг энэ нэр томъёоны оронд “анхдагч дүрслэл”, “архетип” гэдэг нэр томъёог хэрэглэдэг байжээ.

Д.Юмын субъектив идеализм нь танин мэдэхүйн асуудлыг мөн хөнджээ⁹. Түүний бодлоор хүний оюун ухааны бүх перцепци (хүртэхүй) нь бие биенээсээ ангид ялгаатай хоёр төрөлд хуваагддаг бөгөөд түүнийг сэтгэгдэл ба үзэл санаа гэж нэрлэжээ. Ялгаа нь оюун ухаанд тусах болон бидний сэтгэлгээ буюу ухамсарт хүрэх замаа гаргаж байгаа хүч чадал ба эрчмийн хэмжээнээс шалтгаалдаг гэжээ¹⁰. Д. Юм үл ухамсарлахуйн хүрээг хөндөж бид өөрийн үзэл санааг сул ба үл мэдрэгдэх шалтгааны улмаас сэтгэгдлээс ялгаж чаддаггүй тал бий¹¹ гэжээ.

И.Кант нь мэдрэхүйгүй ямарч зүйлийг бид үл мэдэх ба оюун бодолгүй ямар ч зүйл сэтгэдэггүй. Агуулгагүй үзэл бодол нь хоосон, ойлгохуйгүй бясалгахуй сохор¹² гэж үздэг байв. “Санаа нь анхнаасаа л мэдрэхүйгээр “өвчилсөн” байдаг. Мэдрэхүй нь түүнээс гадуурх онцгой бүтцээр дүүрсэн байдаг”¹³, өөрөөр хэлбэл, хүн зөвхөн мэдрэхүй, оюун бодол,

оюун ухаанд тулгуурлаж сэтгэх чадвартай гэжээ.

И.Кант “Цэвэр оюун ухааныг шүүн шүүмжлэхүй” бүтээлдээ бүх сэтгэхүйн ба танин мэдэхүйн үйл явцууд зөвхөн бодит объектыг бясалгах үед л үүсдэг гэжээ. Түүний уг санаанд менталитетийн асуудал сэтгэхүй, хүртэхүйн хэв маягаар илэрхийлэгддэг гэж ойлгож болох юм. “Аперцепци нь сэтгэхүйн хамт аливаа төсөөллийн бүх боломжит тодорхой журмаас урьтал оршдог. Тиймээс аливаа юмыг ерөнхийд нь сэтгэхдээ, түүнийг нэг талаас мэдрэхүйгээрээ тодорхойлохдоо бид ямар ч байсан ерөнхийд нь болон хийсвэрээр (in abstracto) төсөөлж буй юмыг уг бясалгахуйн аргаас ялгадаг. Ингэхдээ бидэнд юмыг зөвхөн сэтгэхүйн тусламжтайгаар тодорхойлох арга л үлддэг. Гэвч тэр нь зөвхөн агууламжгүй логик хэлбэр. Нөгөөтэйгүүр, энэ нь бидний мэдрэхүйгээр хязгаарлагдсан бясалгахуйд хамаардаггүй объектийн өөрийн оршихуйн арга мэт санагддаг”¹⁴ гэжээ.

Иоганн Готлиб Фихте нь И.Кантын адил сэтгэхүйн хэв маяг нь түүний рефлексээс хамаардаг бөгөөд оюун ухааны чадвар ба оюун санааны баримжааллын гүн дэх давхаргыг багтаадаг гэж үздэг байжээ.

Огюст Кант нь “Позитив философийн курс” хэмээх бүтээлдээ хүний сэтгэлөөрийн хөгжлийн явцад теологийн (батлагдаагүй санааны ноёрхол), метафизикийн (бодит гэж хүлээн зөвшөөрөгдөж буй уг чанарыг танин мэдэх), шинжлэх ухааны (позитивизм, оюун ухаан ба ажиглалтын

⁸ *Философия. Учебник. Под ред. проф. В.Н.Лавриненко, В.П.Ратникова. М., 1998. с. 116.*

⁹ *Юм, Д. Сочинения в 2 т. М., Мысль, 1996. с. 503*

¹⁰ *Юм Д. Сочинение в 2 томах. М., 1996, т.1. стр. 62*

¹¹ *Там же. С. 63*

¹² *Кант И. Собр.соч. Т.3.М., 1994.с. 155*

¹³ *Философия. Справочник студента. 2000. С.140.*

¹⁴ *Кант И. Собр.соч. в 8 т. Т.3. М., 1994.с. 267.*

тусламжтайгаар танин мэдэх) гэдэг гурван үе дамждаг гэж үздэг байв. Позитив сэтгэлийн хөгжлийн метафизик үе шатнаас өмнө сэтгэхүйн хэв маяг, өөрөөр хэлбэл, сэтгэхүйн менталь баримжааллууд өөрчлөгддөг гэж үздэг байжээ.

Өрнө дахины философид онтологийн аспектанд менталитетийн асуудал нь этнологийн хүрээнд яригдаж байсан юм. Үүнтэй холбоотойгоор Ш.Монтескье¹⁵, Ж.Бюффон¹⁶ нарын үзэл бодлыг доор дурдах нь зүйтэй гэж үзэж байна.

Ш.Монтескьегийн “Хуулийн утга санааны тухайд” хэмээх бүтээл нь М.Блок, Л.Ле Февр, Леви-Брюль, Г.Бутуль болон бусад судлаачдын онолыг хэлбэржих үйл явцад маш их нөлөө үзүүлж, уг онолуудыг үүсэхэд урьдчилсан нөхцөлийг бүрэлдүүлсэн гэж хэлж болно.

Ш.Монтескье цаг агаарын янз бүрийн нөхцөлд оюун ухааны шинж болон зүрхний хөөрөл нь өөр өөр байдаг гэдгийг тэмдэглэжээ. Иймд хууль нь эдгээр шинж ба сэтгэл хөөрөлтэй нийцэх ёстой¹⁷ гэжээ.

Түүний үзлээр ард түмний ёс зүйн шинжүүдэд газар зүйн хүчин зүйлүүд нөлөөлдөг.

Тухайлбал, халуун уур амьсгал нь өмнө зүгийнхний шашны итгэл үнэмшлийн статик байдлыг нөхцөлдүүлэн, хүмүүсийг сул дорой байдалд оруулдаг, секс харьцааг идэвхжүүлдэг, олон эхнэртэй болох нөхцөлийг бий болгодог, залхуу хойрго болгодог.

Үүний улмаас тэнд хөдөлмөрийн маш

харгис хэлбэр болох боолчлол бий болжээ. Харин хойд зүгийнхэн бол санаачлагатай, эрч хүчтэй, зоригтой, эрх чөлөөг эрхэмлэдэг¹⁸ гэж тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл, биеийн байдал сэтгэлд нөлөөдөг гэдгийг Ш.Монтескье тэмдэглэж байжээ.

“Менталитет” хэмээх ойлголтын бүрэлдэн тогтох асуудал, түүний үндсэн утгыг судлахад Г.В.Ф.Гегелийн концепци дахь “ард түмний санаа” гэдэг ойлголт маш их анхаарал татдаг. Нөгөөтэйгүүр, Гегелийн “ард түмний санаа” нь менталитет гэдэг ойлголттой утгын хувьд ойролцоо гэж үзэж болох боловч адил биш юм.

Гегелийхээр “ард түмний санаа” нь “туйлын санааны” нэг илэрхийлэл. Ийм учраас субстанцийн хувьд бодгалийг нилээд нарийн тодорхойлжээ. Бодгаль нь “ут субстанцийн ахуйг эзэмшиж ... түүний оюун ухааны хэв маяг нь адил болдог ба чадвар нь бодит ахуйг эсвэл аливаа нэг юмыг илэрхийлэх хүртэл хөгждөг. Яагаад гэвэл түүний өмнө ард түмний ахуй нь бэлэн, бат бүх ертөнц шиг байдаг бөгөөд тэрээр түүнийг дагах ёстой” гэж Гегель “Түүхийн философийн тухай лекцдээ” дурджээ. Гегель “ард түмний оюун санаа”-г тайлбарлахдаа “төр, түүний хууль, байгууллагууд нь төрийг бүрдүүлдэг хувь хүмүүсийн эрхийн уг чанар; түүний байгаль, хөрс, уул, агаар ба ус нь тэдгээрийн эх орны мөн чанар, гадаад баялаг нь; уг төрийн түүх, тэдний үйлдэл болон өвөг дээдсийн хийсэн зүйлүүд нь тэд нарт хамаардаг, санаанд нь хадгалагддаг. Тэд төрд хамаардаг шиг төрд буй бүх юм

¹⁵ Монтескье Ш.Л. О духе законов. М., Мысль.1999. с.672.

¹⁶ Бюффон Ж. Всеобщая и частная естественная история. ч.1-10. СПб. С. 1802-1827.

¹⁷ Монтескье Ш.Л. О духе законов. М., Мысль.1999. с.189

¹⁸ Герье В. Философия истории от Августина до Гегеля. М. 1915.с.55-60. Монтескье Ш.Л. О духе законов. М., Мысль.1999. с.189.

тэдний баялаг болдог. Яагаад гэвэл төр нь тэдний субстанции, ахуйг бүрэлдүүлдэг бөгөөд тэдний төсөөлөлд нэвтэрч орсон байдаг ба хүсэл зориг нь уг хууль, энэхүү эх оронг хүсдэг юм. Энэхүү нийлбэр нь нэгдмэл нэг амьтан, нэгдмэл ард түмний оюун санааг бүрэлдүүлдэг” гэж лекцдээ дурджээ. Гегелийн бодлоор уг ард түмний оюун санаанд бүх хувь хүмүүс хамаардаг, “... төр нь хөгждөг учраас нэг ч бодгаль түүний ард үлддэггүй, харин түрүүлж явдаг; түүний төлөөлөгч болдог, түүнээс үүсч, түүнд оршдог. Энэхүү ард түмний оюун санаа нь тодорхой санаа ба өөрийн хөгжлийн түүхэн үе шатны хувьд ч тодорхой байдаг. Хожим энэхүү санаа нь түүний өөрийн ухамсрын бусад хэлбэрийн үндэс ба агуулга нь болдог”¹⁹ гэжээ.

Мөн Уг санааг Гегель хөгжлийн үе шатны тухай асуудлыг тайлбарлахдаа хөндсөн. Түүний үзэж байгаагаар өөр үе шат бүр өөрийн тодорхой зарчимтай. Түүхэнд ийм зарчим нь оюун санааны тодорхой байдал гэх ард түмний онцгой санаа юм. Энэхүү ард түмний онцгой оюун санаа нь “ тухайн ард түмний шашин, улс төрийн бүтэц, ёс суртахуун, эрх зүйн тогтолцоо, зан авиараар” ялгарах шинж болоод зогсохгүй мөн түүний шинжлэх ухаан, урлаг ба техникийн чадамжийн шинж болдог. Энэхүү тусгай онцлогуудыг ерөнхий онцлогоос, ард түмний онцгой зарчмаас олох хэрэгтэй; нөгөөтэйгүүр, түүхэнд өгөгдсөн баримтаас тухайн онцлогийн ерөнхий зарчмыг олж авах хэрэгтэй. Тодорхой онцлог нь жинхэнэ утгаараа ард түмний зарчмыг бүрэлдүүлдэг гэдгийг эмпирик

¹⁹ Гегель Г.В.Ф. Лекции про философию истории. Часть 3. С. 103

үүднээс хүлээн зөвшөөрөх ба түүхийн хувьд нотлогдох ёстой”²⁰ гэжээ. Хожим нь “уг ард түмний зарчим”-ыг францын “Анналы” сургуулийн төлөөлөгчид “менталитет” гэдэг ойлголтоор орлуулж олон зуун жилийн эмпирик баримт дээр тулгуурлан өөрийн бүтээлүүддээ нотлохыг өнөө хүртэл зорьсон гэж хэлж болох юм.

Гегелийн үзэж байгаагаар “дэлхийн түүхэнд ард түмэн бүр өөрийн яруу найраг, урлаг, шинжлэх ухаан ба философитэй; гэвч зөвхөн хэв маяг, чиглэлээрээ ерөнхийдөө хоорондоо ялгаатай байгаад зогсохгүй мөн агуулга нь ч ялгаатай байдаг. Энэ агуулгын ялгаа нь хамгийн чухал ялгаа болох оюун ухааны ялгаанд хамаардаг”²¹, өөрөөр хэлбэл энэхүү “ард түмний зарчим” гэдэг нь ард түмэн бүр хоорондоо ялгагддаг менталиттэй гэдэгтэй төсөөтэй гэж хэлж болох юм. “Ард түмний тодорхой санааг заавал танин мэдэх хэрэгтэй. Түүнийг оюун санаагаар, бодлоор ойлгож болдог. Зөвхөн ард түмний тодорхой санаа л ард түмний бүх үйл ажиллагаа ба эрмэлзэлээр илэрхийлэгддэг”²² гэдэг Гегелийн бодол нь эдүүгээгийн менталитет гэдэг ойлголтын агуулгатай төсөөтэй гэж хэлж болох юм.

Гегель “ард түмний оюун санаа”-г өөрийн ухамсартай бодит байдал, амьдрахуйтай холбоотой бөгөөд өөрийн ухамсартай санаагаар илэрхийлэгдсэн байгаль гэж нэрлэжээ. Гегелийхээр “ард түмний оюун санаа” нь өөрийн ес зүйтэй.

²⁰ Гегель Г.В.Ф. Лекции про философию истории. Часть 3. С. 113

²¹ Гегель Г.В.Ф. Лекции про философию истории. Часть 3. С. 113

²² Там же. С.117

Ес зүй нь бие даасан хувь хүний мэдрэхүй, ухамсар, хүсэл болон сонирхолд бус харин төрийн бүх гишүүдийн нийтлэг сонирхлоос бүрддэг”²³. Хүн бүр “ард түмний оюун санааг” тээдгийн хувьд уг санаа болон түүний мөн чанарыг мэдэх ёстой ба “ард түмний санаатай” эв нэгтгэйгээ ухамсарлан ойлгож, түүний давуу байдлыг хүлээн зөвшөөрөх ёстой²⁴ гэж үздэг байжээ.

Ард түмэн бүр түүхэн хөгжлийн үе шатандаа зохицуулж, өөрийн ухамсарын бүх хэлбэрийн (шашин, урлаг, философи) үндэс, агуулга нь болдог тодорхой санааг хэлбэржүүлдэг.

“Иймээс нэгдмэл бие даасан байдал нь өөрийн мөн чанараараа шашинд бурхан гэж хүлээн авдаг, урлагт түүнийг дүрс, бодит төсөөлөл гэж харуулдаг бол философид санаа гэж танин мэддэг ба ойлгодог. Тэдний субстанции, агуулга ба судлагдахуун нь анхандаа адилхан байдгийн улмаас уг хэлбэрүүд төрийн санаатай тасрашгүй нэгдлийг бий болгодог; энэхүү төрийн байгууламжийн хэлбэр нь тухайн төрд зөвхөн тухайн философи ба урлагийн адил зөвхөн тухайн шашны үед л орших боломжтой байдаг”²⁵ ажээ.

Бодгаль нь субстанции ахуйг эзэмших явцад түүний тодорхой санааны хэв маяг төлөвшдөг, тодорхой чадвар нь хөгждөг, хүн нь өөрийгөө ард түмний санаа бодол болон дэлхийн түүхэн үйл явцтай хамт өөрийгөө ухамсарлаж эхэлдэг. Бодгаль нь өөрийн ухамсраа ард түмний бодит ахуй

болох “тэмүүлж буй бат бөх ертөнц”²⁶-ийн нөлөөнд бүрэлдэн төлөвшүүлдэг гэжээ.

Үүнээс гадна “ард түмний оюун санаа” бие даасан янз бүрийн бодгаль хоорондын мөргөлдөөнийг зохицуулагчийн үүрэг гүйцэтгэдэг.

“Туйлын санаа” нь дээрх үүргийг зарим ард түмэн, төрийн хувьд гүйцэтгэдэг ба шүүн тунгаадаг ажээ.

Уг үзэл бодлоос үүдэн түүх бол бүх дэлхийн шүүх хэмээх төсөөлөл бүрэлдэн тогтсон гэж үздэг тал байдаг.

“Ард түмний санаа”, “ард түмний зарчим”-ын талаар Гегелийн дэвшүүлсэн санаанд хожим нь менталитет гэдэг ойлголтыг хэрэглээнд оруулсан олон тооны эрдэмтэн судлаач, сэтгэгч нар тулгуурлаж түүнийг хөгжүүлсэн гэж үзэж болно. Гэхдээ дээрх ойлголтууд нь өөрийн агуулгаараа хоорондоо төсөөтэй боловч бүрэн утгаараа адилхан гэж дүгнэж болохгүй ажээ. Нөгөөтэйгүүр, Гегель нь түүх, ард түмний санааны төлөвшилт болон дэлхийн түүхэн хөгжил ба туйлын санааны өөрийгөө танин мэдэх үйл явц нь сэтгэхүй, ухамсарын үйл явц, сэтгэхүйн хэв маягийг зохион бүтээхгүйгээр, тодорхой менталь суурьгүйгээр явагдах боломжгүй гэж үздэг байжээ.

Монтескье, Гегель болон өмнөх үеийн сэтгэгчид авч үзэж буй феноменуудыг сэтгэхүйн хүрээнд түүний үйл явц, сэтгэхүйн төсөөлөл, ухамсарын үндэсний онцлог ба зан төлөв байдлыг тусгаж буй философийн категорийг бий болгох хөрсийг бэлдэж өгчээ. Гегелийн философи нь угсаатны ухамсарын онцлогуудын

²³ Гегель Г.В.Ф. *Философия истории*. М., 1977. с.93.

²⁴ Там же, с.99

²⁵ Гегель Г.В.Ф. *Философия истории*. М., 1977. с.102.

²⁶ Там же, с. 122

талаарх сургаалийн хувьсалд их хэмжээний нөлөө үзүүлсэн юм.

Гегелийн “Ард түмний оюун санаа”-г цааш нь О.Бауэр, К.Реннер, Х.Штейнталь, М.Лацарус, В.Вундт, Г.Лебон, Э.Берн нар хөгжүүлж, менталитетийн нийгмийн ба угсаатны аспектыг төлөвшүүлэх үйл ажиллагааг үргэлжлүүлжээ.

“Эмпирик сэтгэлзүйн” үндэслэгч И.Гербарт нь бодгаль хоорондын сэтгэлзүйн үйл ажиллагааны ялгааг тэдний сэтгэлийн (душа) хоорондын харьцааны үр дүнгийн үүднээс үздэг байжээ. Энэ чиглэлээр түүний шавь Х.Штейнталь, М.Лацарус болон германы зарим философчид ажилладаг байлаа. Тэд Гербартын хүмүүсийн сэтгэл хоорондын харилцааг түүхэн тодорхой сэтгэлзүйн нэг хэлхээ гэж үзээд, энэ нь хэл, зан үйл, нийгмийн байгууллага гэх мэтээр илэрхийлэгддэг, түүнээс “ард түмний санаа” бий болдог гэж үздэг байлаа. Өөрөөр хэлбэл, бодгалийн сэтгэлзүй “ард түмний сэтгэлзүй” хүртэл өргөжиж, угсаатны зүй, хэлшинжлэл болон түүхийн аргуудыг хэрэглэдэг бие даасан шинжлэх ухааны салбар бий болсон юм. “Ард түмний сэтгэлзүйг” хуульчлах үйл явцад ард түмний хэл, домог, зан үйлийг угсаатны ухамсрын илэрхийллийн хувьд задлан шинжилж байсан В.Вундт (1822-1920) нилээд хувь нэмэр оруулсан гэж үздэг.

В.Вундт ард түмний сэтгэлзүйн орших эрхийг үгүйсгэж болохгүй гэж тэмдэглэснээр Лацарус, Штейнталь нарын үзэж байснаар сэтгэлзүйн объект нь мөн чанарын хувьд ухамсрын өгөгдсөн байдал

болно ²⁷. Харин энэхүү ухамсрын өгөгдсөн байдал нь ард түмний менталитетийг хэлж буй ажээ.

В.Вундтын бодлоор ард түмний сэтгэл гэдэг нь субъектуудын ганцаарчилсан илэрхийллээр бүрддэг, харин тэдний харилцан үйлчлэл нь ард түмний, бие хүний өвөрмөц онцлогуудыг төрүүлдэг. “Сэтгэл судлалын оршил” бүтээлдээ: “Лацарус, Штейнталь нар хувийн сэтгэлзүйд ард түмний сэтгэлзүйг сөргөлдүүлж тавьсан. Ард түмний сэтгэлзүй нь хувийн сэтгэлзүйн нэмэлт ба шаардлагатай үргэлжлийн үүргийг гүйцэтгэх ёстой байв. Иймд зөвхөн түүнтэй холбогдсоноор сэтгэлзүйн судалгааны зорилтыг бүрэн гүйцэтгэнэ”²⁸ гэж В.Вундт бичжээ. “Ард түмний сэтгэлзүйн асуудлууд” гэдэг өөр нэг бүтээлдээ В.Вундт ард түмний сэтгэлзүйн үндсэн зүйлүүдийг тодорхойлжээ. “Уг ирээдүйн шинжлэх ухааны объектод зөвхөн хэл, домог, шашин ба зан авир орохоос гадна шинжлэх ухаан, соёл түүний хөгжил, ерөнхийд нь болон түүний бие даасан салаанууд, ард түмний түүхэн хувь заяа ба мөхөл, түүнчилэн бүх хүн төрөлхтний түүх багтана. Гэхдээ судалгааны бүх хүрээ нь хийсвэр, тодорхой хэмээх хоёр хэсэгт хуваагдах ёстой.

Хийсвэр хэсэг нь зарим ард түмэн болон тэдний түүхийг хамруулахгүйгээр “үндэсний оюун санааны” ерөнхий нөхцөл ба хуулийг тайлбарлахыг оролддог. Харин тодорхой хэсэг нь зарим ард түмний санаа, тэдний хөгжлийн онцгой хэлбэрийг тодорхойлох зорилготой.

²⁷ Вундт В. Проблемы психологии народов. СПб., Питер., 2001. с.23

²⁸ Вундт В. Введение в психологию. СПб., 2002. с.128

Үүний улмаас ард түмний сэтгэлзүйн бүх хүрээ нь “ард түмний түүхийн сэтгэлзүй” ба “угсаатны сэтгэлзүй” гэж хуваагддаг”²⁹ гэж тэрээр бичжээ.

В.Вундт нь Ш.Монтескьегийн адил ард түмний санаа (менталитет) хэлбэржих үеийн нэг чухал шинжийг тэмдэглэжээ. Түүний үзэж байгаагаар менталь ерөнхий баримжааллууд нь нийгмийн сэтгэлзүй, эдийн засаг, байгаль-цаг уур ба бусад нөхцөл байдлын нөлөөллөөс хэлбэрждэг. Ингэхдээ ард түмний сэтгэлзүй нь юуны түрүүнд соёлын суурь, заншил, уламжлал, домог ба шашны итгэл үнэмшлийг судлах замаар ард түмний санаа бий болох үндсэн зүй тогтлыг илрүүлэх ёстой юм.

В.Вундтын туршлагын аргуудын эрх зүй үр ашигтай гэдэгтэй санал нийлэхгүй байгаагаа В.Дильтей илэрхийлсэн юм. Түүний үзэж байгаагаар хүний сэтгэцийг байгалийн шинжлэх ухааны аргаар судлах боломжгүй зөвхөн ойлгох боломжтой. Ард түмний сэтгэлзүйн зорилго нь бие хүний сэтгэлийн амьдралын утга учир, хүний үнэлэмжийн баримжааллыг илэрхийлэхэд оршдог. Харин үүнд нь тайлбарлах замаар бус ойлгохуйн замаар л хүрэх боломжтой гэжээ. Энэ ялгаа нь хожим ирээдүйн герменевтикийн үндэс болсон гэдэг юм. Дильтейгийн бодлоор “ойлгохуйн сэтгэхүй” нь цаашид түүх, урлаг, ёс зүй, уран зохиол ба бусад санааны тухай бүх шинжлэх ухааны үндэс нь болно.

Дээрх байдлаас үүдэн XX зууны хоёрдугар хагаст угсаатны сэтгэцийг судлах хоёр чиглэл бий болсон юм. Уг чиглэлүүдийн ялгаа нь энэхүү феномений асуудлыг судлах гносеологийн өвөрмөц

байдалд оршдог байжээ.

Нэг чиглэл нь сэтгэцийн бодит илэрхийллийг тайлбарлаж байсан бол нөгөөдөх нь өөрийн анхаарлаа “ард түмний санаа”-г ойлгох асуудалд төвлөрүүлжээ.

Харин К.Маркс, Ф.Энгельс нартай холбоотой өрнө дахины философийн уламжлалын хувьсал нь арай өөр зарчмаар явагджээ. Марксизм нь анхаарлаа эдийн засаг ба нийгмийн асуудал, ангийн тэмцэлд хандуулсан байна. Нийгэм эдийн засгийн формацийн дэс даараалалтай солилцох бүдүүвч нь түүхийн үйл явцын тухай төсөөллийг хүмүүсийн “хүсэл зоригийн санамсаргүй мөргөлдөөн” гэдэг санаанаас чөлөөлсөн юм.

Марксизм нь өөрийн анхаарлаа үйлдвэрийн хүч ба үйлдвэрийн харилцааны хоорондын хамаарал, суурь ба давхаргын диалектикт хандуулснаар нийгэм, улс төрийн хөгжлийн мөн чанарыг ойлгох явцад маш хүчтэй түлхэц өгсөн аж. Угсаатны ба нийгмийн хэмээх хоёр нэгдлээс марксизм нь нийгмийн нэгдлийг судлах үйл явцад илүү анхаардаг байжээ. Өөрөөр хэлбэл түүхэн материализм нь өөрийн сонгодог хэлбэрээрээ нийгмийн ухамсрын үндэслэлийг боловсруулах үйл ажиллагааг илүү эрхэмлэдэг байсны улмаас “менталитет” гэдэг асуудал тэр чигээрээ хаягдсан гэж хэлж болох юм. Үүний улмаас л марксизмын үеийн түүхийг “хүнгүй түүх” гэж нэрлэдэг.

Менталитет нь хүний зан төлөв байдалд нөлөө үзүүлдэг гэдгийг эрдэмтэн судлаачид анзаарчээ. Иймд бихевиоризм хэмээх сэтгэлзүйн энэ чиглэлийг дурдахгүйгээр орхиж болохгүй гэдэг нь

²⁹ Вундт В. Введение в психологию. СПб., 2002. с.128

ойлгомжтой юм.

Бихевиоризмийг үндэслэгч Ж.Уотсон “сэдэл-хариу” гэдэг үүднээс зан төлөв байдлыг тайлбарлаж байжээ. Тэгвэл шинэ бихевиоризмийн төлөөлөгч Э.Толмэн түүний “сэдэл-хариу” гэдэг бүдүүвч нь зан төлөв байдлын үйлдлийг (акт) зөвхөн аливаа сэдлийн энгийн хариуны нийлбэрийн хувьд ханддаг учраас энэ нь зан төлөв байдлыг бүрэн хэмжээгээр тайлбарлаж чадаагүй, хязгаарлагдмал, хэт их гэнэн гэжээ. Цаашилбал, үүний улмаас зан төлөв байдал нь өөрийн өвөрмөц шинжээ алддаг гэж тэрээр үздэг байжээ. Иймд Ж.Уотсоны “молекуляр зан төлөв байдал” гэдэг ойлголтыг “моляр” гэдэг ойлголтоор сольж тайлбарлажээ. Э.Толмэны сэтгэлзүйн тогтолцоо нь бихевиоризм гештальтсэтгэлзүй, гүн дэх сэтгэлзүй ба бусад чиглэлүүдтэй нийцэж байгаад оршдог ажээ. Э. Толмэн нь олон тооны туршлагад тулгуурлан “дотоод үйл явцын тогтолцооны” тухай төсөөлөл дэвшүүлж энэхүү дотоод үйл явц нь сэдэл, хариу хоёрын завсарт нэвтрэн орж зан төлөв байдлыг тодорхойлдог гэж «Хүн ба амьтны зорилгот зан авир» (Purposive behavior in animals and men. New York—London, 1932) бүтээлдээ тайлбарлажээ. Э.Толмэн өөрийн судалгааныхаа явцад амьтны тархинд “когнитив зураг” бүрэлддэг гэж үзэн цаашид организм нь өөрийн зан төлөв байдлаа энэхүү когнитив зургийн дагуу чиглүүлдэг гэж үздэг байлаа. Когнитив зураг гэдэг нь гаднаас орж ирж буй нөлөөг боловсруулсны үндсэн дээр амьтны тархинд бүрэлдэн тогтдог бүтэц юм. Тэрээр амьтны зан араншинг хамгийн эгзэгтэй мөчид адил сэдэлд яг

ижил хариу гаргахад нөлөөлдөг гэжээ. Энэхүү танин мэдэхүйн зургийн нийлбэр нь амьдрахуйн янз бүрийн нөхцөл байдалд зөвхөн амьтан бус мөн хүн адилхан чиг баримжаатай болдог гэж Э.Толмэн үздэг байжээ. Өөрөөр хэлбэл, тэрээр амьтны судалгаанаас гаргасан дүгнэлтийг хүнтэй холбож үздэг байжээ.

“Mens, mentis” хэмээх үгтэй язгуур нэг гэж үзэж болох ойлголтын талаар сэтгэл судлаач Э.Толмен “Зан төлөв байдал моляр үзэгдэл болох нь” бүтээлдээ “сэтгэц” бол мөн чанарын хувьд “дотоод үйл явдлын” урсгал гэж хүлээн зөвшөөрдөг хүнийг менталист гэж тодорхойлсон байдаг. Хүн гэдэг амьтан “өөрийн дотоод ертөнцийг” харснаар “сэтгэцийн дотоод үйл явдлуудаа”³⁰ ажигладаг. Харин амьтан өөрийгөө ухамсарлаж чаддаггүй эсвэл ямар нэгэн иймэрхүү “өөрийгөө ажиглахуйн” үр дүнгийн тухайд тайлагнах чадваргүй ч тэд өөрийн “сэтгэцийн дотоод үйл явдлуудтай” гэж менталистууд үздэг.

Улмаар, уг “дотоод үйл явдлуудын” талаарх дүгнэлтийг амьтны гадаад зан араншингаар нь тодорхойлж болно гэж тэд үздэг юм байна. Өөрөөр хэлбэл, амьтны “сэтгэцийн зүйл зүйлийн үүрэг өөрийн физик гүйцэтгэлээс үл хамаардаг” бөгөөд аливаа физик байдал нь түүний дотоод ухараахуйгаар үл оршдог гэж тэд үздэг.

Харин бихевиористууд эсрэг байр суурийг илэрхийлдэг. Тэдний үзэж байгаагаар “сэтгэцийн үйл явц” нь зан төлөв байдлын тододгогч болдог ч эцэст нь түүгээрээ л илэрдэг гэжээ. Харин зан авир нь үл ухамсарлахуйн

³⁰ Вундт. В. Проблемы психологии народов. СПб. 2001. с.9-10

нөлөөний улмаас илэрхийлэгддэг учраас түүнд төрөлхийн шинжүүд шингэсэн байдаг. Тийм учраас л субъект нь бусад субъектуудын адил заавал ижил үйлдэл хийдэг. Өөрөөр хэлбэл, субъектив байдал зөвхөн тусгагдаж буй обьектив байдлын агуулгаар илэрхийлэгддэггүй байна.

Энэ субъектив байдалд анхнаасаа л уг үйл явцыг тусгах боломжтой, өөрөөр хэлбэл, обьектив байдлыг тусгах арга зам, технологи, хэлбэрийн тухай мэдээлэл агуулагддаг гэж үздэг. Тэгэхлээр “мэдлэгийн өмнөх мэдлэг” гэсэн парадокс бий болж энэ нь менталь чанар, өөрөөр хэлбэл, менталитетыг илэрхийлж буй хэлбэрийн нэг болоод байгаа юм. Ер нь танин мэдэхүйн ямарч үйлдлийг танин мэдэж буй субъектийн шинж чанараас, түүнийг хүрээлж буй орчноос ангид авч үздэггүй.

Олон янзын ард түмний оюун санааны хөгжил нь зарим менталь үндэс, баримжааллыг өөрчлөх нөхцөл болдог. Харин энэхүү өөрчлөлтүүд нь юуны өмнө ард түмний, домгийн, шашны ертөнцийг үзэхүйд болон хэлний хэлбэрт илэрдэг ажээ.

Менталитетын түүхэн замналыг шинжлэхэд түүнийг цаг хугацааны хүрээтэй, бие биетэйгээ харилцан оршдог, харилцан бүрдүүлдэг үндсэн гурван үе шатаар дамжсан гэж үздэг тал бий.

Эхний үе шатанд уг ойлгохуйн хөгжил нь нуугдмал байдалтай явагдаж, “менталитет” хэмээх нэр томъёо нь хүн төрөлхтний янз бүрийн нийгмийн өвөрмөц ертөнцийг төсөөлөхүйн хэв маягийг хайхад зориулагдсан философийн

бүтээлүүдэд огт дурьддаггүй байжээ. Философи нь бодит байдлын үл мэдэх хүрээг “ард түмний сэтгэл”, “ард түмний санаа”, “угсаатны ухамсар” гэх мэт нэр томъёог ашиглаж түүнийг илэрхийлдэг байжээ.

Хоёр дахь үе шат нь “шинэ түүхийн шинжлэх ухаан” бий болсонтой холбоотой. Уг шинжлэх ухааныг Францын түүх-антропологиин “Анналы” сургууль төлөөлдөг байсан ба “хүнгүй түүхийг” судлах боломжгүй гэдэг санааг өөрийн анхаарлын төвд тавьсан юм. Иймд “менталь чанар” нь “нийгмийн бүх гишүүд нь шингэсэн” өвөрмөц түүхэн соёлын “эфирийн” үүргийг гүйцэтгэдэг ажээ. Харин түүх нь өнгөрсөн цагийн хүмүүсийн дотоод ертөнцийг дахин бүрэлдүүлэхэд уг байдлыг харгалзах ёстой юм. “Менталитет” хэмээх асуудлыг гаргаж, түүнийг нийгмийн шинжлэх ухааны төлөөлөгчдийн дунд түгээснээр уг хоёрдугаар үе шатны ач холбогдол нь илэрхийлэгддэг ч уг асуудлыг бүрэн шийдвэрлэж чадаагүй юм.

Менталитетын тухай ойлголт бүрэлдэн төлөвших гуравдахь үе шат нь сэтгэлзүй, социологи, угсаатан судлал болон хүмүүнлэгийн шинжлэх ухааны бусад тодорхой салбарт дасан зохицох үйл ажиллагаатай холбоотой ба уг салбар ухаанууд менталитетын талаар өөрийн тодорхойлолтыг санал болгосон. Бий болсон уг нөхцөлд менталитетын талаар санал болгосон олон тооны үзэл баримтлалыг нийгэм философийн үүднээс дахин ухаарах, дараа нь тэднийг системчлэх, журамлах шаардлага гарч ирсэн. Өөрөөр хэлбэл, “хоёр дахь

үгүйсгэл” явагдаж өмнө үгүйсгэгдэж байсан категори нь түүхэн агуулгаар баяжсанаар шинэ учир холбогдолтой болсон.

НОМ ЗҮЙ

1. Библер В.С. Итоги и замыслы: Конспект философской логики культуры //Вопросы философии. М., 1993, №5. с.75
2. Бюффон Ж. Всеобщая и частная естественная история. ч-1-10. СПб. с.1802-1827.
3. Вундт В. Проблемы психологии народов. СПб., Питер., 2001, с.23
4. Вундт В. Введение в психологию. СПб., 2002, с.128
5. Вундт. В. Проблемы психологии народов. СПб., 2001, с. 9-10
6. Гегель Г.В.Ф., Философия истории. М., 1977, с.102.
7. Там же, с.122
8. Гегель Г.В.Ф. Лекции про философию истории. Часть 3. с. 103
9. Гегель Г.В.Ф. Лекции про философию истории. Часть 3. с. 113
10. Гегель Г.В.Ф. Лекции про философию истории. Часть 3. с. 113
11. Там же. С.117
12. Гегель Г.В.Ф. Философия истории. М., 1977, с.93.
13. Там же, с.99
14. Герье В. Философия истории от Августина до Гегеля. М., 1915, с.55-60
- 15.Ц.Гомбосүрэн. Философи сурах бичиг. УБ., 2008. 36-р тал
- 16.Кант И. Собр.соч. Т.3.М., 1994, с.155
17. Кант И. Собр.соч. в 8 т. Т.3. М.,1994.с. 267.
18. Льюис Дж.Г. Античная философия: от Фалеса до Сократа. Минск, 1997, с. 38
19. Монтескье Ш.Л. О духе законов. М., Мысль. 1999, с.189.
20. Монтескье Ш.Л. О духе законов. М.,Мысль.1999, с.672.
21. Монтескье Ш.Л. О духе законов. М.,Мысль.1999, с.189
22. К.Тацит. Анналы. Малые произведения. История. М., 2004, с.986
23. Р.Эмерсон. О доверии к себе. М., 1900, с. 3
24. Там же. с.4.
25. Юм.Д. Сочинения в 2 т. М., Мысль, 1996, с. 503
26. Юм Д. Сочинение в 2 томах. М., 1996, т.1. стр. 62
27. Там же, с. 63
28. Соционика, ментология и психология личности. 1997, с.115
29. Философия. Учебник. Под ред.проф. В.Н.Лавриненко, В.П.Ратникова. М.,1998, с.116.
- 30.Философия. Справочник студента. 2000, с.140.
31. Хрестоматия по истории психологии. Под ред. П.Я.Гальперина, А.Н.Ждана. М. Изд-во МГУ. 1999, с. 138.

ABSTRACT

Some scholars consider the historical development of mentality as transition through three basic stages: chronology, interconnectedness and interdependence.

The term “mentality” is defined differently by researchers, however, in general, there are common understandings about the complex structures, which consists of rational and irrational elements and form the basis of social mentality framework, that is applied everywhere. Moreover, conditions of the world and the society have been changing continuously and the process of mentality development, relatively. Thus, we cannot refer to the process of mentality development as sustainable, it has been required to analyze and assess the behavior, tendency and orientation of mentality of any country, nationality and society.